



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/442

Номгон


“Булаг” хүнсний дэлгүүрийн “Согтууруулах  
ундаа худалдах тусгай зөвшөөрөл”-ийг  
хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 14/08 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 6.1.8 дахь заалт, Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 2021/ЗШ/123, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 2021/ЗШ/265 дугаартай шийтгэвэрүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй зөрчиж архи согтууруулах ундаа худалдан борлуулсан Баянхонгор сумын 3 дугаар багийн иргэн Д.Баатархуяг эзэнтэй “Булаг” хүнсний дэлгүүрийн “Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл”-ийг 2 жилийн хугацаатай хүчингүй болгосугай.

2.Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон Д.Баатархуяг эзэнтэй “Булаг” хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210025

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx